



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/197

Ховд

┌ Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг /улаан түвшин/-т 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд шилжүүлсүгэй.

2.Захирамжийг хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Сумдын Засаг дарга, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/194 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДУГЭРЖАВ